



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Чулуут сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/102/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн:
Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар
Ахлах аудитор Ч.Анхбаяр
Утас: 8511-6555
Цахим хаяг: ankha964@gmail.com

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
5.1 Төлбөрийн акт.....	11
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2025.02.25 № 142
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЧУЛУУТ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ё.ДУЛАМСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Чулуут сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант жилийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 130,523.3 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлэхээр төлөвлөж, Сангийн яамны цахим системд нэгтгүүлсэн ба төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ дүнгээр алдаатай тайлагнасан;

ЭМТ-ийн даргын тушаалаар 27,000.0 мянган төгрөг, Чулуут сумын засаг даргын захирамжаар 3,000.0 мянган төгрөгийн нийт 30,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшууллыг албан хаагчдад хавтгайруулан олгосон;

Тайлант жилд нийт 5200.0 мянган төгрөгийн шагнал олгож төсвийг зориулалт бус зарцуулсан;

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.3.2, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, 16.5.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.5, 20.2.6, 20.2.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар

зүйлийн 4.1.3, 15.1.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журам, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалын холбогдох заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,195,253.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 25,897.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 63,500.0 мянган төгрөг, урьд оны санхүүжилтийн үлдэгдэл 276,046.7 мянган төгрөг, нийт 1,560,698.0 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, үйл ажиллагаанд гүйцэтгэлээр 1,400,174.7 мянган төгрөгийг зарцуулж, төрийн сангийн харилцах дансанд 30,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 үндсэн зорилтын хүрээнд 96 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, арга хэмжээний хэрэгжилтийг Чулуут сумын Засаг дарга 92,0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>335,037,719.49</u>	<u>240,925,906.78</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	145,523,385.39	30,000,010.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	145,523,385.39	30,000,010.00
3121	Төгрөг	145,523,385.39	30,000,010.00
31211	Төрийн сангийн харилцах	145,523,385.39	30,000,010.00
33	АВЛАГА	20,684,310.00	40,882,599.90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	20,684,310.00	40,882,599.90
35	БАРАА МАТЕРИАЛ	168,830,024.10	170,043,296.88
351	Түүхий эд материал	103,291,749.02	102,707,582.26
35110	Тусгай зориулалттай материал	55,613,278.49	50,170,671.55
35130	Эм боох материал	47,678,470.53	52,536,910.71
354	Хангамжийн материал	65,538,275.08	67,335,714.62
35410	Бичиг хэргийн материал	1,405,950.00	2,326,650.00
35420	Аж ахуйн материал	47,359,825.08	52,112,921.62
35430	Сэлбэг хэрэгсэл	1,485,000.00	1,485,000.00
35440	Түлш, шатах тослох материал	13,223,300.00	8,994,250.00
35460	Хүнсний материал	1,624,700.00	1,977,393.00
35470	Бусад хангамжийн материал	439,500.00	439,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>679,438,945.94</u>	<u>1,004,982,234.11</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	679,438,945.94	1,004,982,234.11
392	Биет хөрөнгө	666,870,945.94	992,414,234.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	495,084,792.65	495,084,792.65
39202	Хуримтлагдсан элэгдэл	-87,489,792.61	-96,900,613.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,209,158.00	318,222,724.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,564,863.02	168,956,970.7
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	206,760,095.67	346,719,195.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-29,624,470.02	-58,931,437.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,442,440.00	63,384,515.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-9,208,386.73	-15,189,943.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,346,230.00	9,146,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-84,258.00	-164,258.00
393	Биет бус хөрөнгө	12,568,000.00	12,568,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,568,000.00	12,568,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,014,476,665.43</u>	<u>1,245,908,140.89</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>1,200,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,200,000.00
413	Өглөг	-	1,200,000.00
4136	Бусад өглөг	-	1,200,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,014,476,665.43</u>	<u>1,244,708,140.89</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,014,476,665.43	1,244,708,140.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	238,055,180.58	238,055,180.58
51101	Өмч: - төрийн	238,055,180.58	238,055,180.58
512	Хуримтлагдсан үр дүн	642,283,250.54	872,514,726.00
51210	Өмнөх үеийн үр дүн	642,283,250.54	642,283,250.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	230,231,475.46
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	134,138,234.31	134,138,234.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,014,476,665.43</u>	<u>1,245,908,140.89</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,148,188,615.43	1,688,697,329.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,387,550.11	447,347,729.57
120	Нийтлэг татварын бус орлого	153,387,550.11	447,347,729.57
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	120,648,074.45	418,091,945.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	63,500,000.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө	120,648,074.45	354,591,945.40
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал	32,739,475.66	29,255,784.17
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	994,801,065.32	1,241,349,600.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,476,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,476,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,293,000.00	25,897,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,293,000.00	25,897,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	969,031,265.32	1,215,452,100.13
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	969,031,265.32	1,215,452,100.13
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	899,196,195.03	1,458,465,854.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	899,196,195.03	1,458,465,854.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	899,196,195.03	1,415,465,854.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,176,699.93	908,545,700.32
210101	Үндсэн цалин	334,015,403.73	475,533,933.68
210102	Нэмэгдэл	136,782,905.20	353,429,948.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,317,000.00	25,574,452.86
210104	Урамшуулал	73,072,523.28	54,007,365.27
210105	Гэрээт ажлын хөлс	23,988,867.72	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,397,100.00	122,634,000.00
210201	Тэтгэврийн даатгал	50,151,300.00	89,762,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,561,400.00	8,218,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,449,000.00	4,868,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,112,400.00	3,546,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,123,000.00	16,239,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,995,660.44	25,097,889.56
210301	Гэрэл, цахилгаан	5,002,010.44	5,408,842.00
210302	Түлш, халаалт	15,798,050.00	19,381,500.00
210303	Цэвэр, бохир ус	195,600.00	307,547.56
2104	Хангамж, бараа материалын зардал	67,334,331.20	72,147,161.20
210401	Бичиг хэрэг	6,901,823.00	7,537,450.00
210402	Тээвэр, шатахуун	30,223,388.00	49,511,070.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,497,000.00	7,107,356.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,225,460.20	7,707,884.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,486,660.00	283,400.00
2105	Норматив зардал	109,401,217.00	193,218,786.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	95,012,367.00	170,660,129.93
210502	Хоол, хүнс	14,388,850.00	13,965,657.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	8,593,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,669,200.00	11,993,040.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	305,000.00
210602	Тавилга	-	384,400.00
210604	Урсгал засвар	3,669,200.00	11,303,640.00
2107	Томиллолт, зочны зардал	6,012,000.00	7,196,000.00
210702	Дотоод албан томиллолт	6,012,000.00	7,196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	898,310.00	6,301,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,755,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	1,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	135,000.00

Архангай аймгийн Чулуут сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,000.00	154,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,310.00	106,950.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,311,676.46	68,331,286.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,048,300.00	15,423,399.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,263,376.46	52,907,887.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	43,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	43,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	43,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	248,992,420.40	230,231,475.46
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	248,992,420.40	230,231,475.46

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	974,116,755.32	1,284,651,310.23
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	63,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	63,500,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	63,500,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	63,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	974,116,755.32	1,221,151,310.23
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,476,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,476,800.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,293,000.00	25,897,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,293,000.00	25,897,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	948,346,955.32	1,195,253,810.23
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	948,346,955.32	1,195,253,810.23
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	862,763,099.93	1,376,315,455.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	862,763,099.93	1,376,315,455.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,763,099.93	1,333,315,455.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	579,176,699.93	908,545,700.32
210101	Үндсэн цалин	334,015,403.73	475,533,933.68
210102	Нэмэгдэл	136,782,905.20	353,429,948.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,317,000.00	25,574,452.86
210104	Урамшуулал	73,072,523.28	54,007,365.27
210105	Гэрээт ажлын хөлс	23,988,867.72	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,397,100.00	122,634,000.00
210201	Тэтгэврийн даатгал	50,151,300.00	89,762,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,561,400.00	8,218,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,449,000.00	4,868,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,112,400.00	3,546,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,123,000.00	16,239,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,293,000.00	25,897,500.00
210301	Гэрэл, цахилгаан	5,002,010.44	5,408,842.00
210302	Түлш, халаалт	17,016,000.00	20,324,500.00
210303	Цэвэр, бохир ус	274,989.56	164,158.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,685,688.00	68,324,626.30
210401	Бичиг хэрэг	4,025,000.00	6,814,250.00
210402	Тээвэр, шатахуун	41,589,058.00	44,216,020.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,497,000.00	7,107,356.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,128,410.00	4,715,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,446,220.00	5,472,000.00

Архангай аймгийн Чулуут сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Норматив зардал	98,205,302.00	172,713,929.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,572,100.00	147,138,979.00
210502	Хоол, хүнс	14,758,502.00	14,474,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,874,700.00	11,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,008,900.00	13,395,810.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,924,900.00	-
210602	Тавилга	-	570,310.00
210604	Урсгал засвар	10,084,000.00	12,825,500.00
2107	Томилолт, зочны зардал	6,012,000.00	7,196,000.00
210702	Дотоод албан томилолт	6,012,000.00	7,196,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	898,310.00	5,101,990.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,755,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	120,000.00	135,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,000.00	154,260.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73,310.00	106,950.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,086,100.00	9,505,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,086,100.00	9,505,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	43,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	43,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	43,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	111,353,655.39	-91,664,145.39
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27,982,800.00	23,859,230.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,982,800.00	23,859,230.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27,982,800.00	23,859,230.00
222001	Тоног төхөөрөмж	27,982,800.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	23,859,230.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(27,982,800.00)	-23,859,230.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	83,370,855.39	-115,523,375.39
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		145,523,385.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	145,523,385.39	30,000,010.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	238,055,180.58	134,138,234.31	642,283,250.54	1,014,476,665.43
D08	Тайлант үеийн үр дүн			230,231,475.46	230,231,475.46
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	238,055,180.58	134,138,234.31	872,514,726.00	1,244,708,140.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь

Архангай аймгийн Чулуут сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,551,918,700.00	1,400,174,685.62	151,744,014.38	90.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,551,918,700.00	1,400,174,685.62	151,744,014.38	90.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,508,918,700.00	1,357,174,685.62	151,744,014.38	89.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	915,203,400.00	908,545,700.32	6,657,699.68	99.3
210101	Үндсэн цалин	473,127,000.00	475,533,933.68	-2,406,933.68	100.5
210102	Нэмэгдэл	311,967,900.00	353,429,948.51	-41,462,048.51	113.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,732,000.00	25,574,452.86	-18,842,452.86	379.9
210104	Урамшуулал	123,376,500.00	54,007,365.27	69,369,134.73	43.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	122,634,000.00	122,634,000.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	89,762,100.00	89,762,100.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,218,000.00	8,218,000.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,868,700.00	4,868,700.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,546,100.00	3,546,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	16,239,100.00	16,239,100.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,897,500.00	25,897,500.00	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,968,300.00	5,408,842.00	3,559,458.00	60.3
210302	Түлш, халаалт	15,648,300.00	20,324,500.00	-4,676,200.00	129.9
210303	Цэвэр, бохир ус	1,280,900.00	164,158.00	1,116,742.00	12.8
2104	Хангамж, бараа материалын зардал	91,271,800.00	68,324,626.30	22,947,173.70	74.9
210401	Бичиг хэрэг	6,907,100.00	6,814,250.00	92,850.00	98.7
210402	Тээвэр, шатахуун	64,975,100.00	44,216,020.00	20,759,080.00	68.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,202,600.00	7,107,356.30	2,095,243.70	77.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,715,000.00	4,715,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,472,000.00	5,472,000.00	0.00	100.0
2105	Норматив зардал	177,011,900.00	172,713,929.00	4,297,971.00	97.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	145,519,100.00	147,138,979.00	-1,619,879.00	101.1
210502	Хоол, хүнс	16,342,800.00	14,474,950.00	1,867,850.00	88.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,150,000.00	11,100,000.00	4,050,000.00	73.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,811,400.00	32,455,040.00	53,356,360.00	37.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,700,000.00	6,599,900.00	44,100,100.00	13.0
210602	Тавилга	20,000,000.00	13,029,640.00	6,970,360.00	65.1
210604	Урсгал засвар	15,111,400.00	12,825,500.00	2,285,900.00	84.9
2107	Томилолт, зочны зардал	9,600,000.00	7,196,000.00	2,404,000.00	75.0
210702	Дотоод албан томилолт	9,600,000.00	7,196,000.00	2,404,000.00	75.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,311,000.00	5,101,990.00	54,209,010.00	8.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,741,000.00	3,755,780.00	53,985,220.00	6.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550,000.00	500,000.00	50,000.00	90.9
210803	Даатгалын үйлчилгээ	135,000.00	135,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,000.00	154,260.00	740.00	99.5
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	150,000.00	106,950.00	43,050.00	71.3
210807	Газрын төлбөр	80,000.00		80,000.00	0.0

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	450,000.00	50,000.00	90.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,177,700.00	14,305,900.00	7,871,800.00	64.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,177,700.00	14,305,900.00	7,871,800.00	64.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,000,000.00	43,000,000.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,000,000.00	43,000,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,000,000.00	43,000,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,551,918,700.00	1,284,651,310.23	267,267,389.77	82.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,897,500.00	25,897,500.00	0.00	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	25,897,500.00	25,897,500.00	0.00	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,186,474,500.00	1,195,253,810.23	-8,779,310.23	100.7
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,186,474,500.00	1,195,253,810.23	-8,779,310.23	100.7
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	339,546,700.00	63,500,000.00	276,046,700.00	18.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	63,500,000.00	63,500,000.00	0.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	276,046,700.00		276,046,700.00	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		145,523,385.39	145,523,385.39	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		30,000,010.00	-30,000,010.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	34	34	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16	16	0.00	100.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу илэрхийлсэн 130,523.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрсэн бөгөөд Сангийн яамны цахим системд нэгтгэгдсэн шалтгаанаар залруулагдаагүй болно. Залруулагдаагүй алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

Урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн бодит үлдэгдэл 145,523.4 мянган төгрөг байхад түүнээс 130,523.3 мянган төгрөгийн илүү дүнгээр санхүүжүүлэх алдаатай тооцож төлөвлөн Сангийн яамны цахим системд нэгтгүүлсэн байна. Үүний улмаас тайлант оны төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 130,523.3 мянган төгрөгөөр илүү тусгаснаар тус байгууллага нь бодитоос 151,744.0 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан мэтээр алдаатай тайлагнасан байна.

Аудитаар нийт 59,059.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг бус алдааны зөрчил нь 23,859.0 мянган төгрөг, материаллаг алдааны зөрчил нь 35,200.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

материаллаг байдлын дүн 10,863.4 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант жилд эмч, сувилагчийн баяр тохиолдуулан 4000.0 мянга, шинэ жилийг тохиолдуулан 1,200.0 мянга нийт 5200.0 мянган төгрөгийн шагнал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт буцаан төвлөрүүлэх акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1 Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 14 нэр төрлийн 31 ширхэг 83,169.6 мянган төгрөгийн хөрөнгөнд холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүлээ

5.2.2 Тайлант жилд Байгууллагын дотоод журамд тодорхой заалтгүй 30,000.0 мянган төгрөгийн орон сууцны дэмжлэгээр нэг удаагийн тэтгэмжийг 17 ажилтанд хавтгайруулан олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;"

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох байх албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд 23,859.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн

хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасугай” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой.

Илрүүлэлт:

Тайлант жилийн төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 130,523.3 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлэхээр төлөвлөж, Сангийн яамны цахим системд нэгтгүүлсэн ба төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ дүнгээр алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг бодит эх үүсвэрээс илүү төлөвлөж Сангийн яаманд нэгтгүүлсэн алдааг давтан гаргахгүй байх, төсвийн төлөвлөлт, тайлагналд тавих хяналтыг сайжруулж, үнэн зөв тайлагнах арга хэмжээ авах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн хөрөнгийн урьд оны үлдэгдлээс	1	130,523.3			1	130,523.3			1	130,523.3	1	130,523.3

Архангай аймгийн Чулуут сумын ЭМТ-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

илүү төлөвлөсөн												
Дүн	1	130,523.3			1	130,523.3			1	130,523.3	1	130,523.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шагнал олгосон	1	5,200.0	1	5,200.0								
Үлдэх өртөггүй хөрөнгийг хугацааг сунгаж үнэлэх	1	0			1	0						
Орон сууцны дэмжлэгийг хавтгайруулж олгосон	1	30,000.0			1	30,000.0						
Шууд гэрээгээр үндсэн хөрөнгө худалдан авалт хийсэн	1	23,859.0					1	23,859.0				
Дүн	4	59,059.0	1	5,200.0	2	30,000.0	1	23,859.0				